

**МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2024 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
	ЗОРИЛТ 1. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.	ДЭД БҮТЦИЙН ТОО	ХӨГЖЛИЙН БОДЛОГОД УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР ТУСГАГДСАН.	1 БАЙРШИЛД УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ПОСТ, 2 ХҮРТЭЛХ БАЙРШИЛД УСАН ЗАМЫН ХӨВДӨГ ЗОГСООЛ СУУРИЛУУЛЖ, ТУСГАЙ ТОНОГЛОЛ БҮХИЙ АВРАХ ЗАВЬ 1-ИЙГ ХӨВӨЛТӨД ГАРГАНА.	IV УЛИРАЛ	82.1
1.1	Монгол орны зарим томоохон нуурын эрэгт усан замын тээврийн хяналтын пост байгуулах	Хяналтын пост, тоо	УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Хөвсгөл нуураас бусад орон нутаг дахь томоохон нуурын эрэгт усан замын тээврийн хяналтын пост, зогсоол байгуулах ажлын зураг төслийг боловсруулах талаар тусгагдсан.	1-р улиралд: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. 2-р улиралд: 1 байршилд усан замын тээврийн хяналтын пост зөөврийн байгууламжийг хүлээж авсан байна.	2024 онд Архангай аймгийн Өгий нуурын эрэгт усан замын тээврийн “Хяналтын пост” байгуулахаар төлөвлөсөн бөгөөд тус ажлын хүрээнд: - Хяналтын байрыг зөөврийн сууцаар шийдэхээр “Ноц констракшн ХХК”-тай 2024 оны 03 сард гэрээ байгуулсан. Зөөврийн сууцыг 2024 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хяналтын постын газарт суурилуулж, акт үйлдэн хүлээн авсан. - “Гадна цахилгааны шугам татах, дэд өртөө байгуулах” ажлыг тендерийн сонгон шалгаруулалтаар “Мокса инженеринг” ХХК-иар гүйцэтгүүлсэн. Далайн захиргаааны даргын 2024 оны А/123 дугаар тушаалаар байгуулсан комисс 07 дугаар сарын 21-ний өдөр Өгий нуурт ажиллаж, гадна цахилгааны ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан. Хяналтын байр цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт бүрэн холбогдсон.	100

					- Эко ариун цэврийн байгууламжийг суурилуулах ажлыг “Чингүн хат” ХХК-иар гэрээгээр гүйцэтгүүлж, 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авсан.	
1.2.	Орон нутгийн эрэлт хэрэгцээг нь харгалзан усан замын хөвдөг зогсоол суурилуулах	Хөвдөг зогсоолын тоо	МУ-ын Засгийн газраас 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол орны томоохон нууруудын эрэгт тохижилт бүхий усан замын хөвдөг зогсоол суурилуулахаар төлөвлөөд байна.	1-р улиралд: Сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 2-р улиралд: Ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна. 3-р улиралд: Усан замын зогсоолыг суурилуулж, ашиглалтад оруулсан байна.	Төлөвлөгөөний дагуу 2024 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Архангай аймгийн Өгий нуур болон Хөвсгөл нуурын эрэгт усан замын хөвдөг зогсоолуудыг тус тус суурилуулсан. Хөвдөг зогсоол нийлүүлэгчийн багц тендерийн сонгон шалгаруулалтад “Халиун проперти” ХХК шалгарсан бөгөөд тус компанитай 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Далайн захиргааны даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/86 дугаар тушаалаар байгуулсан Ажлын хэсэг 05 дугаар сарын 30-ны өдөр ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, акт үйлдэн ашиглалтад хүлээн авсан.	100
1.3.	ХБНГУ-ын Далайн эрэн хайх, авран туслах байгууллагаас буцалтгүй тусламжаар өгөх тусгай тоноглол бүхий аврах завийг оруулж ирэх ажлыг зохион байгуулах	Ажлын гүйцэтгэлийн хувь	Далайн захиргаанаас усан замын тээврийн хяналтын техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор ХБНГУ-ын Далайн эрэн хайх, авран туслах байгууллагад 2023 онд хүсэлт гарган дахин 1 аврах завийг буцалтгүй тусламжаар авахаар харилцан тохиролцсон.	1-р улиралд: Сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 2-р улиралд: Тээвэрлэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажилласан байна. 3-р улиралд: Аврах завийг хүлээн авах, хөвөлтөд гаргах ажлыг зохион байгуулсан байна.	ХБНГУ-ын Далайн эрэн хайх, авран туслах байгууллага нь буцалтгүй тусламжаар өгөх аврах завинд шаардлагатай засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсний дараа буюу 2024 оны 06 дугаар сард багтаан Германиас БНХАУ-ын Тяньжин боомт руу далайгаар илгээх тухайгаа албан ёсоор мэдэгдсэн. Үүнтэй холбоотойгоор аврах завийг оруулж ирэх ажлын Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хоёр удаа зохион байгуулсан. Эхний сонгон шалгаруулалтад ямар нэгэн оролцогч санал ирүүлээгүйн улмаас амжилтгүй болсон. Хоёр дахь сонгон шалгаруулалтыг 2024 оны 07 дугаар сарын 08-22-ны хооронд зохион байгуулахад “Эй Си Дабльо Транс” ХХК	100

					шалгарсан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулсан. Аврах завийг тус компани 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь хяналтын постод хүлээлгэн өгсөн. Хөвсгөл аймагт хөвөлтийн улирал дуусаж байгаатай холбоотойгоор аврах завийг өвлийн зогсоолд нь байрлуулаад байна.	
ЗОРИЛТ 2. “ХУУРАЙ БООМТЫН ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-Т ТУСГАГДСАН БАЙРШЛУУДЫГ ТОДОРХОЙЛЖ, ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ АЖЛУУДЫГ ХИЙНЭ.		СУДАЛГАА-НЫ АЖЛЫН ЯВЦ	МУ-ЫН ЕРӨНХИЙ САЙДЫН 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН 111 ДҮГЭЭР ЗАХИРАМЖААР АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДСАН. ЗТХ-ИЙН САЙДЫН 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН А/270 ТООТ ТУШААЛААР ДЭД АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАГДСАН.	БАРУУН КОРИДОРТ ХОВД, ТӨВИЙН КОРИДОРТ ЗАМЫН-ҮҮД, УЛААНБААТАР, ЗҮҮН КОРИДОРТ БИЧИГТ, /ЧОЙБАЛСАН/ ГЭСЭН БАЙРШЛУУДАД СУДАЛГАА ХИЙСЭН БАЙНА.	I-IV УЛИРАЛ	
2.1.	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан байршлуудад нөхцөл байдлын үнэлгээ хийх	Төлөвлөгөөний хэрэгжилт явц	МУ-ын Ерөнхий сайдын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 111 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. ЗТХ-ийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/270 тоот тушаалаар Дэд ажлын хэсэг байгуулагдсан.	1-р улиралд: Ажлын даалгаврыг боловсруулж, батлуулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна. 2-р улиралд: Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьсан байна. 3-р улиралд: Үнэлгээний дүгнэлтийг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан байршлуудад нөхцөл байдлын үнэлгээ хийх хийх ажлын даалгаврыг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр баталсан. Тендерийн урилгыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр цахим системд нийтэлж, 05 дугаар сарын 09-ний өдөр нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, ирүүлсэн оролцогчдын материалыг хянан үзэж шалгарсан оролцогчтой гэрээ байгуулан хамтарч ажилласан. “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т тусгагдсан байршлуудад нөхцөл байдлын үнэлгээ	100

					хийх судалгааны танилцуулга, дүгнэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/370 тоот албан бичгээр ЗТЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.	
2.2.	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралтад тусгагдсан байршлуудыг тодорхойлох болон зах зээлийн судалгаа хийх	Судалгааны ажлын явц	ӨМӨЗО-ны “Бүс ба зам” судалгааны хүрээлэнтэй хамтын ажиллагаа тогтоохоор ажиллаж байгаа ба хамтын ажиллагааны хүрээнд баруун болон төвийн коридор дээр хамтарсан судалгаа хийхээр харилцан тохиролцсон. Ляонин их сургуультай хамтын ажиллагаа тогтоож, зүүн коридорын дагуух бүс нутгийн хот суурин газруудыг хөгжүүлэх судалгаа хийхээр урьдчилж санал солилцсон.	2-р улиралд: “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралтад тусгагдсан байршлуудыг урьдчилсан байдлаар тодорхойлсон байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба Зам” судалгааны хүрээлэнтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд хамтран бодлогын судалгаа боловсруулах ажлыг зохион байгуулсан байна. 3-р улиралд: БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба Зам” судалгааны хүрээлэнтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд зах зээлийн судалгаа боловсруулах ажлыг зохион байгуулсан байна. БНХАУ-ын Ляонин Их сургуулийн Зүүн хойд Азийн судалгааны хүрээлэнтэй хамтран ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба Зам” судалгааны хүрээлэнтэй байгуулсан санамж бичгийн хүрээнд зах зээлийн	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралтад тусгагдсан байршлуудыг тодорхойлох болон зах зээлийн судалгаа хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/16 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба зам” судалгааны хүрээлэнтэй 2023 оны 12 дугаар сард байгуулсан Санамж бичгийн хүрээнд судалгаа хийхээр тохиролцсон. 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр ӨМӨЗО-ны Нийгмийн шинжлэх ухааны академийн “Бүс ба Зам” судалгааны хүрээлэнгийн захирал Фан Лижун хүрэлцэн ирж хоёр талын судалгааны ажлын явцын талаар хэлэлцүүлэг өрнүүлж, холбогдох зөвлөмж, саналаа солилцож ажиллав. Баруун бүсийн Ховд, Зүүн бүсийн Бичигт байршлуудад судалгаа хийх зорилгоор судалгааны ажлын цар хүрээ, төлөвлөгөөг урьдчилсан байдлаар холбогдох судлаачтай хэлэлцэсний үндсэн дээр ӨМӨЗО-ны Санхүү, эдийн засгийн их сургуультай хамтран судалгаа хийхээр тохиролцож, Санамж бичгийг 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. “Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хавсралтад тусгагдсан байршлуудыг тодорхойлох судалгааны танилцуулгыг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/369 тоот албан бичгээр, Хуурай боомтын	100

				судалгаа боловсруулах ажлыг зохион байгуулсан байна.	байршлуудад зах зээлийн судалгааны танилцуулга, дүгнэлт саналыг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/370 тоот албан бичгээр тус тус ЗТЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.	
2.3.	“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Дорноговь аймгийн Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах бэлтгэл ажлыг хангах	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах сонгон шалгаруулалтын үе шат	Хэлэлцээрийн хавсралтад 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хуралдаанаар нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан.	1-р улиралд: Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах Техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын даалгавар боловсруулж, батлуулсан байна. 2-р улиралд: Замын-Үүд дэх “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах ТЭЗҮ боловсруулах ажлыг зохион байгуулсан байна.	Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулахаар шийдвэрлэсэн. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллах ажлын төлөвлөгөөний төсөл болон холбогдох чиглэлүүдийн хүрээнд ажлын хэсгүүд байгуулах ажлын удирдамжийн төслийг боловсруулан ЗТХЯ-ны ДАУЗТХ-т 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/11 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Замын-Үүд суман дахь “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн ажлын даалгаврыг боловсруулан төслийг Зам, тээвэр хөгжлийн дэд сайдад 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр биечлэн танилцуулсан. Гэвч ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах төсөв ЭЗХЯ-нд тусгагдаагүй шалтгаанаар хойшлогдоод байна. ЗТХ-ийн дэд сайдаас өгсөн чиглэлийн дагуу “Замын-Үүд хуурай боомт” байгуулах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын суурь судалгаа боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, судалгааны ажлыг	30

					<p>мэргэжлийн зөвлөх үйлчилгээний байгууллагаар гүйцэтгүүлсэн ба холбогдох тайланг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/441 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Мөн Засгийн газрын 2024 оны 11 дүгээр тогтоолоор ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардагдах хөрөнгийг ЭЗХ-ийн сайдад үүрэг болгосон бөгөөд уг тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд ЭЗХЯ-ны 2025 оны батлагдсан төсвөөс санхүүжүүлэх талаар арга хэмжээ авч өгөх хүсэлтийг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01/559 тоот бичгээр ЗТЯ-нд хүргүүлээд байна.</p>	
--	--	--	--	--	--	--

2.4.	Бүс нутгийн тээврийн коридорыг хөгжүүлэх, Замын-Үүд, Бичигт байршлуудад хуурай боомт байгуулахад хөрөнгө оруулалт татах чиглэлээр ажиллах	Арга хэмжээний тоо	БНХАУ-ын ӨМӨЗО болон Ляонин мужтай хамтын ажиллагаа тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ажиллаж байна.	<p>2-р улиралд: БНХАУ-ын Ляонин мужийн 5 дугаар экспод оролцох бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна.</p> <p>3-р улиралд: Экспо арга хэмжээнд оролцож, хөрөнгө оруулалтын хамтарсан форум зохион байгуулсан байна.</p>	<p>БНХАУ-ын Ляонин мужийн ардын засгийн газрын худалдааны хэлтсээс экспо арга хэмжээний хөтөлбөрийг эцэслэн 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар ирүүлсний дагуу холбогдох бэлтгэл ажлыг хангаж ажилласан.</p> <p>“БНХАУ-ын Ляонин мужийн олон улсын 5 дахь удаагийн хөрөнгө оруулалт, худалдааны форум” арга хэмжээ 2024 оны 09 дүгээр сарын 26-29-ний өдрүүдэд Шэньян хотод эдийн засаг, худалдаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт чиглэлээр зохион байгуулагдсан ба Ляонин мужийн ардын засгийн газрын худалдааны газрын урилгаар Далайн захиргааны төлөөлөл оролцож, форум арга хэмжээний үеэр Монгол Улсад байгуулах хуурай боомтуудын байршил болон хөрөнгө оруулалтын боломжийн талаар танилцуулж, холбогдох уулзалтуудыг хийж ажиллав.</p> <p>Томилолтын тайланг 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01/412 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p>	100
2.5.	Буйр нуурт усан замын боомт байгуулах хөгжлийн концепц боловсруулах	Судалгааны ажлын явц	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн №39 дүгээр тогтоол, Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний 4.1.1.5 дах заалт	<p>1-р улиралд: Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах талаар холбогдох байгууллагуудтай уулзалт хийж, шаардлагатай мэдээллийг авч ажилласан байна.</p> <p>2-р улиралд: Усан замын боомт байгуулах боломжийн талаарх судалгааг боловсруулж холбогдох санал, дүгнэлтийг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>Улирлын чанартай "Буйр нуур" усан замын боомт байгуулах хөгжлийн концепц боловсруулах судалгаа хийх ажлын хүрээнд дараах ажлуудыг авч хэрэгжүүлэв. Үүнд:</p> <p>-Хилийн боомтын захиргаанд 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/25 тоот "Мэдээлэл хүсэх тухай" албан бичиг хүргүүлсэн. Тус байгууллагаас хариуг 2024.03.20-ны өдрийн 2/566 тоот албан бичгээр ирүүлсэн.</p> <p>-Буйр нуурт усан замын боомт байгуулах нөхцөл байдлын судалгаа боловсруулах худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг бэлтгэн 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр баталж, худалдан авах</p>	100

					<p>ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулж холбогдох аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэв.</p> <p>“Буйр нуурт усан замын боомт байгуулах хөгжлийн концепц боловсруулах” судалгааны тайланг 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 01/276 тоот албан бичгээр ЗТЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.</p> <p>Мөн судалгааны ажлын талаарх танилцуулгыг Боомтын Сэргэлтийн Үндэсний Хорооны хүсэлтээр 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдөр болон 11 дүгээр сарын 29-ний өдөр тус тус танилцуулж, санал солилцож ажилласан.</p> <p>Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 4.1.1.5 дахь заалтад тусгагдсан “Буйр нуурт усан замын боомт байгуулах” ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг байгуулах тушаалын төслийг боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 01/478 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн ба Ажлын хэсэг Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны А/259 дүгээр тушаалаар байгуулагдсан ба Ажлын хэсгийн анхны хурлыг 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр ЗТЯ-ны 301 тоот өрөөнд 15:00 цагт зохион байгуулсан.</p>	
2.6.	Төв аймгийн Хөшигийн хөндий дэх “Чингис Хаан Олон Улсын нисэх буудал”-ыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах олон төрөлт тээврийн	Судалгааны ажлын явц	Монгол Улсын Засгийн газрын 2023.06.07-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл, “Хуурай боомт байгуулах тухай”	2-р улиралд: Судалгааны ажлыг эхлүүлсэн байна. 4-р улиралд:	<p>Төв аймгийн Хөшигийн хөндий дэх Чингис хаан Олон улсын нисэх буудлыг түшиглэн Хуурай боомтод холимог тээврийн нэгдсэн зохион байгуулалтыг бүрдүүлэх судалгааг боловсруулахаар холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэв.</p> <p>Үүнд: -2024 оны 2 дугаар сард БНХАУ-д ажилласан албан томилолтын үеэр Шанхай хотын дагуул хот болох Нантонг</p>	100

<p>холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн судалгаа боловсруулах</p>			<p>Засгийн газар хоорондын хэлэлцээр</p>	<p>Судалгааны санал, дүгнэлтийг боловсруулсан байна.</p>	<p>нисэх буудлын ачааны терминалтай танилцаж, цаашид хамтран ажиллах нөхцөл боломжийг эрэлхийлж, холбоо тогтоов.</p> <p>Олон Улсын чанартай хуурай боомт байгуулах олон төрөлт тээврийн холболт, замын хөдөлгөөний эрчимжлийн судалгаа боловсруулах ажлыг Далайн захиргааны 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулсан.</p> <p>Ажлын даалгаврыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр боловсруулан баталсан. Худалдан авах ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд тус тус зохион байгуулахад 2 удаа амжилтгүй үр дүн гарсан. Дахин худалдан авах ажиллагааг 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулахад шаардлага хангасан оролцогч байгаагүй тул амжилтгүй болсон. Иймд дээрх судалгааны ажлыг байгууллагын дотоод нөөц боломжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хөшигийн хөндий дэх “Чингис хаан Олон Улсын нисэх буудал”-ыг түшиглэн олон улсын чанартай хуурай боомт байгуулах хэрэгцээ шаардлага болон холбогдох танилцуулгыг бэлтгэн 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр ЗТЯ-ны ДАУЗТХ-т цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>Судалгааг нэгтгэн боловсруулж, холбогдох судалгааг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/546 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p>	
				<p>1-р улиралд: Иран, Пакистаны далайн боомтуудын талаар</p>	<p>Иран, Пакистаны далайн боомтуудын талаар судалгааны ажлыг гүйцэтгэх ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p>	<p>100</p>

2.7.	Далайн шинэ боомт ашиглах судалгаа хийх	Судалгааны ажлын явц		<p>судалгааны ажлыг эхлүүлсэн байна.</p> <p>2-р улиралд: Холбогдох судалгааг хийж гүйцэтгэн ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>-Үндэсний статистикийн хорооны Гадаад худалдааны статистик болон Гаалийн Ерөнхий Газрын статистик мэдээ, ЗТХЯ-ны статистик мэдээг цуглуулан боловсруулалт хийгдсэн.</p> <p>-Иран, Пакистаны далайн боомтуудын талаарх мэдээллийг цахим орчинд цуглуулж мэдээллийн сан үүсгэсэн.</p> <p>-Иран, Пакистан улсуудтай холбогдох Хятадын Өрөмч хотын дэд бүтцийн холболт, логистикийн төвийн талаар танилцуулга, мэдээлэл боловсруулсан.</p> <p>- Иран, Пакистан улсуудын далайн боомт хүртэлх далайн тээврийн зах зээлийн үнийн судалгаа хийгдсэн.</p> <p>Судалгааны ажлыг нэгтгэн боловсруулж 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 01/238 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.</p>	
2.8.	БНХАУ-ын далайн боомтуудаас ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах	Ажлын гүйцэтгэл	Холбогдох хэлэлцээр хийгдсэн	<p>2-р улиралд: Судалгаа хийсэн байна.</p> <p>4-р улиралд: Далайн боомтуудаас ачаа тээвэрлэлтийг эхлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p>	<p>Япон Улсаас автомашины тээвэрлэлтийг Хятадын Далянь боомтоор дамжуулан задгайгаар тээвэрлэх нөхцөл боломжийн талаарх тооцоо судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <p>-БНХАУ-ын Ляонин мужийн Шэньяан, Далянь хотод 2024 оны 01 дүгээр сарын 24-28-ны өдрүүдэд томилолтоор ажиллан МУ-ын импортын бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх талаар санал солилцов.</p> <p>-БНХАУ-ын Ляонин мужийн дэд захирагч Жин Гуовэй тэргүүтэй баг бүрэлдэхүүний 2024 оны 08 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн айлчлалын бэлтгэл ажил, айлчлалын хөтөлбөрийг ЗТЯ-ны ТЗУГ-ын ГХХ-тэй хамтран зохион байгуулсан.</p>	100

					<p>-Тус айлчлалын үеэр Далянь боомтоос ачаа тээвэрлэлтийг хөгжүүлэх, ачаа тээвэрлэлтийг саадгүй зохион байгуулах талд хамтарч ажиллах хүсэлтийг тавьж, дэмжиж ажиллахаар тохиролцсон.</p> <p>-2024.09.20-ны өдөр БНХАУ-ын Ляонин мужийн худалдааны хэлтэстэй Далянь боомтоор дамжуулан автомашин задгайгаар тээвэрлэх талаар уулзалт хийж санал солилцож хамтран ажиллаж байна.</p> <p>Туршилтын тээвэрлэлтийг эхлүүлэх ажлын хүрээнд холбогдох дотоодын мэргэжлийн байгууллагуудтай уулзалтуудыг зохион байгуулав. Үүнд:</p> <p>-2024.09.18-ны өдөр МТЗНХ-ны гишүүн Монложистик ХХК, Туушин ХХК-тай автомашины тээвэрлэлтийн талаар санал солилцох уулзалт;</p> <p>-2024.09.19-ний өдөр ГЕГ-тай автомашин задгайгаар тээвэрлэхэд хориг саад байгаа эсэх талаар мэдээлэл авч, хамтарч ажиллах тухай уулзалт;</p> <p>Туршилтын тээврийг зохион байгуулах ажлын хүрээнд БНХАУ-д суугаа ЭСЯ болон ГЕГ-аар дамжуулан Хятадын Гаалийн байгууллагад хүсэлт хүргүүлэх тухай албан тоотын төслийг боловсруулан ЗТЯ-нд 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/442 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Далянь боомттой тохиролцоонд хүрсэн бөгөөд хилийн боомтоор нэвтрүүлэх асуудлыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Хятадын Эрээн хотод зохион байгуулагдсан хоёр улсын хилийн байгууллагуудын комиссын хурлын хэлэлцэх асуудалд тусгуулан хэлэлцүүлж, холбогдох санал, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллав.</p>	
--	--	--	--	--	--	--

2.9.	Хуурай боомтыг түшиглэн Олон Улсын цахим худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах тухай судалгаа боловсруулах	Судалгааны ажлын явц	БНИУ-ын баруун Лигуриагийн Генуя далайн боомттой 2017 онд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.	<p>1-р улиралд: Хуурай боомтыг түшиглэн Олон Улсын цахим худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах тухай судалгааг эхлүүлсэн байна.</p> <p>2-р улиралд: БНХАУ-ын Шанхай хотын цахим худалдааны нэгдсэн сүлжээний талаар туршлага судлах</p> <p>3-р улиралд: БНИУ-ын Ривалта Скривиа хуурай боомтын цахим худалдааны нэгдсэн сүлжээний талаар туршлага судлах.</p> <p>4-р улиралд: Судалгааг нэгтгэн боловсруулж ЗТХЯ-нд хүргүүлнэ.</p>	<p>Хуурай боомтыг түшиглэн Олон улсын цахим худалдааны нэгдсэн сүлжээ байгуулах тухай судалгааны ажил боловсруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p> <p>-Олон улсын цахим худалдааны өнөөгийн байдал цаашдын чиг хандлагын талаар холбогдох мэдээлэл цуглуулан боловсруулалт хийгдсэн.</p> <p>-Бүс нутгийн гадаад худалдааны статистик мэдээлэл болон бусад холбогдох мэдээллийг орчуулан бэлтгэсэн.</p> <p>-БНХАУ-ын Шанхай хотод 2024 оны 01 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд томилолтоор ажиллан, Шанхай хотын цахим худалдааны үйл ажиллагааны талаар туршлага судлах зорилгоор Шанхай хотын Юаньтун цахим худалдааны ачаа тээврийн компани, Шанхай хотын Чөлөөт бүсийн үйл ажиллагаатай танилцаж хамтын ажиллагаа тогтоож ажиллав.</p> <p>-Шанхай хотын “ВЕРО(WERO)” олон улсын байгууллагатай 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Далайн захиргааны байранд уулзалт хийж, хамтын ажиллагааны харилцан ойлголцлын Санамж бичгийг 2024 оны 05 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Цаашид олон улсын чанартай хуурай боомт байгуулах болон олон төрөлт тээврийн холболт, тээвэр логистикийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр судалгаа хийх, зөвлөлдөх уулзалт, семинар зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллахаар харилцан тохиролцов.</p> <p>-БНИУ-ын Ривалта Скривиа хуурай боомтын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах цаашид хамтын</p>	100
------	--	----------------------	---	--	---	-----

					ажиллагаа эхлүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Итали Улсад суугаа Элчин сайдын яаманд болон Бүгд Найрамдах Итали Улсын Баруун Лигуриягийн тэнгисийн боомтын захиргаанд 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр цахим шуудангаар хүсэлтийг хүргүүлсэн бөгөөд ГХЯ-наас холбогдох хариуг ирүүлсний дагуу цахим орчинд хайлт хийж Ривалта скривиа хуурай боомтын үйл ажиллагааны талаар судалгаа хийгдсэн. Судалгааг нэгтгэн боловсруулж 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/542 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	
ЗОРИЛТ 3. ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ, ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦҮҮЛНЭ.		ТӨЛӨВЛӨГӨӨ НИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ	ДАЛАЙ АШИГЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ	ОЛОН УЛСЫН 2 КОНВЕНЦОД НЭГДЭН ОРЖ, 1 СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛЖ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙНЭ.	I-IV улирал	
3.1.	“Далайг хог хаягдал болон бусад зүйлсээр бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай” 1972 оны конвенцын 1996 оны Протоколд нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц	Протоколын орчуулгыг хийж, хянан баталгаажуулахаар танилцуулгын хамт 2023 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 01/296 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.	1-р улиралд: Протоколын монгол хэл дээрх орчуулгыг ГХЯ-аар хянан баталгаажуулсан байна. 2-р улиралд: Хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох баримт бичгийн хамт боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна. 3-4-р улиралд: Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна.	Протоколын орчуулгыг төслийг боловсруулсан бөгөөд ГХЯ-ны 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдөр “Албан ёсны орчуулга”-ыг хянан баталгаажуулсан ба Конвенцын үзэл баримтлал нь ЗТЯ-ны ДАУЗТХ-р боловсруулагдаж дуусаад ХЗДХЯ-р хянуулж баталгаажуулсан. Мөн конвенцын хэрэгжүүлэх талаарх дүн шинжилгээг хийж ЗТЯ-ны ДАУЗТХ-т 2024 оны 12 дугаар сарын 26 01/567 тоот албан бичгээр хүргүүлсэн. ОУДБ-ын Хяналтын зөвлөлөөс 2024 оны 12 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдсан “ОУДБ-ын зүгээс Далбааны эзэн улсыг чадавхжуулах сургалт”-ын үеэр ГХЯ, ХЗДХЯ, ЗТЯ, Далайн захиргааны холбогдох удирдлага, мэргэжилтнүүд тус	30

					сургалтад, семинарт хамрагдсан. Тус семинарыг удирдсан ОУДБ-ын 2 зөвлөхүүдийн санал, зөвлөмжийн дагуу манай улс конвенцын хэрэгжилтийг хангах чадамжийн хувьд сул гэдгийг онцолсон бөгөөд ГХЯ, ХЗДХ, ЗТЯ-ны зүгээс хувьд тус конвенцод нэгдэн орох шаардлагагүй талаар дээрх яамнуудын бодлогын түвшинд дахин авч хэлэлцэх болсон.	
3.2.	“Олон улсын далайн тээврийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх тухай” 1965 оны Конвенц, түүний нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн ороход дэмжлэг үзүүлэн ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц	Конвенцын орчуулгыг хийж, хянан баталгаажуулахаар танилцуулгын хамт 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 01/321 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ТЗДТБЗГ-т хүргүүлсэн.	2-р улиралд: Конвенцын болон нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх орчуулгыг ГХЯ-аар хянан баталгаажуулсан байна. 3-р улиралд: Хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох баримт бичгийн хамт боловсруулж, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн байна. 4-р улиралд: Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна.	ЗТЯ-наас конвенцын орчуулгыг холбогдох журмын дагуу хянуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Олон Улсын Далайн Байгууллагаас 2024 оны 12 дугаар сарын 02-06-ны өдрүүдэд Монгол Улсад зохион байгуулсан “Далбааны эзэн улсыг чадавхжуулах, хүлээх эрх, үүргийн тухай” семинар, сургалтад ОУДБ-ын Ахлах зөвлөхөөс өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улс тус конвенцод нэгдэхээс мөн татгалзсан.	30
3.3.	Усан замын тээврийн салбарын эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх	Ажлын явц	Усан замын тээврийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах талаарх санал боловсруулагдсан байна. Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр	2-улиралд: Хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. 4-р улиралд: Дүн шинжилгээ хийсэн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Усан замын тээврийн тухай хуулиар тусгайлан эрх олгогдсон, Захиргааны хэм хэмжээний актыг нэгдсэн санд бүртгэлтэй Засгийн газрын тогтоолоор болон Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлагдсан нийт 13 дүрэм, журам нь хуульд нийцэж байгаа эсэх, захиргааны хэм хэмжээний актаар зохицуулагдан хэвээр байх эсхүл тухайн харилцааг дүрэм, журмаар бус хуулиар зохицуулах шаардлагатай буюу захиргааны хэм хэмжээний актыг хуульд тусгах эсэхэд дүн шинжилгээ хийсэн.	90

			дагаварт хийх үнэлгээ хийсэн.		<p>Үүний үр дүнд 3 журмын зохицуулалтыг хуульд тусгуулахаар Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан ба санал дүгнэлтээ ЗТЯ-ны Хуулийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан “Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах нь” сэдэвт семинарын үеэр оролцогч усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл, завьчдаас урьдчилан бэлдсэн маягтаар Усан замын тээврийн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар санал асуулга явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан санал, дүгнэлтийг тайланд тусгав.</p> <p>Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу “Нийгэм, эрх зүйн бодлогын судалгааны судлаач хүрээлэн” ТББ-аар гүйцэтгүүлэн тайланг 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/565 дугаар тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.</p>	
3.4.	Усан замын хөвдөг зогсоолыг угсарч, суурилуулах аюулгүйн шаардлага стандартыг боловсруулах	Ажлын явц	“Төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн стандартчиллын техникийн хорооны /ТХ-33/ 2024-2025 оны ажлын төлөвлөгөө”-нд тусгуулах тухай саналыг ЗТХЯ-нд хүргүүлсэн.	<p>2-р улиралд: Стандартын төслийг Үндэсний стандарт боловсруулах MNS стандартад нийцүүлэн боловсруулж дууссан байна.</p> <p>3-р улиралд: Төслийг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.</p>	<p>Усан замын хөвдөг зогсоолыг угсарч, суурилуулах аюулгүйн шаардлага стандартын төсөл боловсруулах судалгааны ажлын хүрээнд Англи Улсын болон бусад орны хэд хэдэн ижил төрлийн стандартын баримт бичгийг гарын авлага болгон ашиглахаар орчуулгын ажлыг хийж гүйцэтгэсэн. Стандартын төслийг Далайн захиргааны даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны</p>	100

					01/552 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	
3.5.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Ажлын явц	Тайланг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 01/201 тоот албан бичгээр ХНХЯ-нд хүргүүлсэн.	2-р улиралд: “Далайн хөдөлмөрийн тухай” конвенцын хэрэгжилтийн тайланг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Шинжээчдийн хорооноос гаргасан асуулгын дагуу англи, монгол хэл дээр боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна.	ОУХБ-ын Далайн хөдөлмөрийн тухай конвенцын хэрэгжилтийн 3 дахь удаагийн тайланг гаргаж, ОУХБ-д уламжлуулахаар 2024 оны 08 дугаар сарын 12-ны 01/322 тоот албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлсэн.	100
3.6.	Монгол Улсын нэгдэн орсон ОУДБ-ын заавал биелүүлэх гэрээ, конвенцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх	Ажлын явц	Далайн ашиглах тухай хуулийн 5.1.3 дахь заалт	3-р улиралд: Конвенцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Монгол Улсын нэгдэн орсон ОУДБ-ын заавал биелүүлэх гэрээ, конвенцын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03/94 дугаартай албан бичгээр ОУДБ-т хүргүүлсэн. Мөн тус ОУДБ-т хүргүүлсэн тайланг Далайн захиргааны даргын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн “Дэмжлэг хүсэх тухай” 01/324 дугаартай албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	0
ЗОРИЛТ 4. ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧАНАРЖУУЛАХ		ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОО	ОЛОН УЛСЫН ДАЛАЙН БАЙГУУЛЛАГААС МОНГОЛ УЛСАД ХИЙСЭН АУДИТЫН ШАЛГАЛТЫН ЗӨВЛӨМЖИЙН 8 ДУГААР ЗӨРЧИЛД ТУСГАГДСАН. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ	ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН 2-ООС ДООШГҮЙ ЗУУЧЛАГЧТАЙ ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, МОНГОЛ УЛСЫН ДАЛБААТАЙ 20-ООС ДООШГҮЙ ХӨЛӨГ ОНГОЦОНД ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙНЭ. УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН 160-С ДООШГҮЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫГ ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫГ ХИЙНЭ.	I-IV УЛИРАЛ	

4.1.	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг өргөжүүлэх	Агентын тоо	2023 онд хөлөг онгоц бүртгэлийн 4 агенттай гэрээ байгуулсан.	2-р улиралд: Хөлөг онгоцны бүртгэлийн 2-оос доошгүй зуучлагчтай холбоо тогтоож, хамтран ажиллах гэрээний нөхцөлийг харилцан тохиролцсон байна. 4-р улиралд: Гэрээ байгуулж, хамтын ажиллагааг эхлүүлсэн байна.	Сингапур Улсад үйл ажиллагаа явуулдаг “Tengri Maritime Services Pte Ltd” компани руу гэрээ байгуулах санал хүргүүлсэн ч ЗТЯ-аас холбогдох гэрээг байгуулах боломжгүй талаар чиглэл ирүүлсэн. БНСУ-ын “Cosmos Marine Bureau” компанитай 12 дугаар сарын 11-ний өдөр хамтран ажиллах гэрээг сунгах, харилцаа, хамтын ажиллагааны талаар тус компанийн эрх бүхий албан тушаалтнууд болох Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал нар Монгол Улсад хүрэлцэн ирж холбогдох уулзалтыг зохион байгуулсан бөгөөд гэрээний нөхцөл болон зарим заалт, үйл ажиллагааны талаар нөгөө БНСУ-ын “Cosmos Marine Bureau”-ны талаас тодорхой санал тавьсны дагуу гэрээг 1 сарын хугацаанд үзэглэхийг хойшлуулсан. Мөн үүнтэй холбоотойгоор хэвлэл мэдээллийн цахим хуудсанд хөлөг онгоц бүртгэлийн зуучлагч, агентын сонгон шалгаруулалттай холбоотой зарлалыг 2024 онд 4 удаа зохион байгуулсан боловч оролцогч материал ирүүлээгүй болно.	0
4.2.	Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх	Гүйцэтгэлийн хувь	Олон улсын далайн байгууллагаас Монгол Улсад хийсэн аудитын шалгалтын зөвлөмжийн 8 дугаар зөрчилд тусгагдсан. 2023 онд хүлээн зөвшөөрөгдсөн 10 байгууллагатай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгуулсан.	4-р улиралд: Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудаас ирүүлсэн үзлэг шалгалтын тайланд дүн шинжилгээ хийж, тайлан гаргасан байна.	Хүлээн зөвшөөрдөгдсөн байгууллагуудаас Монголын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд олгосон техникийн гэрчилгээ болон холбогдох тайланд дүн шинжилгээ хийж тайлан боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 16-ны 01/551 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	100
4.3.	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг	Хяналт шалгалтын тоо	Монгол Улсын далбаатай 15 хөлөг	1-4-р улиралд:	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй 21 хөлөг онгоцонд хяналт	

	онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт хийх		онгоц дээр гэрээт болон Далбааны эзэн улсын хянан шалгагч нар үзлэг шалгалт хийж гүйцэтгэсэн.	Монгол Улсын далбаатай 20-оос доошгүй хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт хийсэн байна.	шалгалтыг хууль тогтоомжийн хүрээнд далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч болон гэрээт хянан шалгагчдаар гүйцэтгүүлсэн. Далбааны эзэн улсын хяналт шалгалт явуулсан тайланг Далайн захиргааны 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/492 дугаартай албан бичгийн хавсралтаар ЗТЯ-ны СХГ-т хүргүүлж тайлагнасан.	
4.4.	Усан замын тээврийн хэрэгслийн 2024 оны техникийн хяналтын үзлэг, тооллогыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	“Усан замын тээврийн тухай” хуульд заасны дагуу усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, тооллогыг жил бүр зохион байгуулдаг.	3-р улиралд: Техникийн хяналтын үзлэг, тооллогыг улсын хэмжээнд зохион байгуулж, дүн мэдээг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 4-р улиралд: Техникийн хяналтын үзлэг, тооллогын тайлан мэдээг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Далайн захиргааны даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан удирдамж, хуваарийн дагуу усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, бүртгэл, тооллогыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Архангай аймгийн Өгий нуур, Тэрхийн цагаан нуур, Баян-Өлгий аймгийн Толбо нуур, Увс аймгийн Хяргас нуур, Ховд аймгийн Хар ус, Далай нуур, Дорнод аймгийн Буйр нуур, Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ мөрөн, Булган аймгийн Эг, Үүрийн бэлчир, Хөвсгөл аймгийн Тэнгис-Шишгэдийн бэлчирт тус тус зохион байгуулсан. 2024 оны техникийн хяналтын үзлэгт нийт 146 усан замын тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд үзлэгт тэнцсэн-123, тэнцээгүй-16, засвартай-7, бусад шалтгаанаар 87 тээврийн хэрэгсэл үзлэгт хамтрагдаагүй болно. Техникийн хяналтын үзлэг, бүртгэл, тооллогын нэгдсэн тайланг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/489 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	100
4.5.				2-р улиралд:	Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 04/02, 04/19 дүгээр удирдамжийн дагуу Архангай, Баян-Өлгий, Булган, Дорнод, Сэлэнгэ, Увс,	100

	<p>Усан замын тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх</p>	<p>Хяналт шалгалтын тоо</p>	<p>Далайн захиргааны мэргэжилтэн, улсын байцаагчид нь усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаа талаар урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт хяналт шалгалтыг жил бүр хийж гүйцэтгэж байна.</p>	<p>Хяналт шалгалтын удирдамжийг батлуулсан байна.</p> <p>3-р улиралд: Батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн байна.</p> <p>4-р улиралд: Тайланг ЗТХЯ-ны СХГ-т хүргүүлсэн байна.</p>	<p>Ховд, Хөвсгөл аймгуудад усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалтгалтын тухай, Усан замын тээврийн тухай хуулиуд, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс 08 дугаар сарын 12-ны өдрүүдэд хянаж шалгасан.</p> <p>Шалгалтад нийт 54 аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн 146 усан замын тээврийн хэрэгсэл хамрагдаж, 388 дутагдлыг илрүүлж, 52 усан замын тээврийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, 7,150,000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулсан.</p> <p>Ажиласан орон нутаг бүрт хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга гаргаж, СХГ-ын хяналтын улсын ахлах байцаагч ТНБД-д танилцуулж ажилласан.</p> <p>Усан замын тээврийг ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай улсын байцаагчийн тоон тайланг 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/526 дугаар албан тоотоор Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.</p>	
4.6.	<p>Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулах, баримт бичгийн бүрдлийг шалгах, тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавих</p>	<p>Шийдвэрлэлтийн явц</p>	<p>Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан 2023 оны А/125 дугаар тушаалаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг Далайн захиргаанд гэрээгээр</p>	<p>1-4-р улиралд: Эрх шилжүүлэх гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	<p>2024 оны жилийн эцсийн байдлаар усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлсэн нийт 66 ААН, иргэний материал хүлээн авч, шаардлага хангаагүй, буруу болон дутуу илгээсэн 32 хүсэлт буцаагдаж, 34 хүсэлтийг шийдвэрлэсэн байна.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2024 оны А/27 дугаар тушаалаар 3 иргэнд</p>	

			гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн.		шинээр, 2024 оны А/115 дугаар тушаалаар 6 иргэнд шинээр, 5 иргэнд сунгалт, 2024 оны А/128 дугаар тушаалаар 2 аж ахуйн нэгжид, 3 иргэнд шинээр, 2024 оны А/141 дүгээр тушаалаар 1 аж ахуйн нэгж, 3 иргэнд шинээр, 2024 оны А/186 дугаар тушаалаар 2 аж ахуйн нэгж, 9 иргэнд шинээр тусгай зөвшөөрөл тус тус олгосон. Далайн захиргаанд гэрээний үндсэн дээр шилжүүлсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/539 тоот албан бичгээр ЗТЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлсэн.	100
4.7.	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэж байгаа хөлөг онгоцыг Монголын даатгалын компанид даатгуулах боломжийг олгох	Шийдвэрлэлтийн явц	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцнууд гаднын орны даатгалын компаниудад даатгуулдаг.	1-р улиралд: Монгол Улсын даатгалын компанид хамтын ажиллагааг эхлүүлж, Санамж бичиг байгуулсан байна. 2-3-р улиралд: Даатгалын компаниудыг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан байна. 4-р улиралд: Монголын даатгалын компанийг хөлөг онгоц эзэмшигч болон зуучлагчид санал болгосон байна.	Монгол Улсын Далайн захиргаа нь Монгол Даатгал ХК-ийн удирдлагуудтай 2024 оны 05 дугаар сарны 09-ний өдөр дахин уулзалт зохион байгуулсан бөгөөд манай талаас компанийг дэмжин ажиллахаа илэрхийлж санамж бичгийг байгуулах ажлыг эрчимжүүлэхийг хүссэн. Тус компанийн удирдлагууд давхар даатгал судлахад хугацаа шаардлагатай байгаа талаар мэдэгдсэн. Хөлөг онгоцны эзэмшигч болон хөлөг онгоцыг төлөөлөгч, зуучлагч агентуудад Монголын даатгалын компани болон бусад орны даатгалын компаниудын даатгалын танилцуулага болон хамтран ажиллах тухай саналыг цахим шуудангаар хамтран ажилладаг агентуудруу хүргүүлсэн. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэж байгаа хөлөг онгоцыг Монголын даатгалын компаниудын санхүү болон бусад чадамжийнх нь хүрээнд даатгуулах боломжтой “Багийн даатгал” буюу Багийн гишүүдийн эрүүл мэнд, амь	0

					нас, ослоор нас барсны тэтгэмж, эмнэлгийн нүүлгэн шилжүүлэлт зэрэг даатгалын үйлчилгээ үзүүлдэг төрлийн даатгалын бүтээгдэхүүн мөн "Хамгаалалт ба нөхөн төлбөрийн (P&I) даатгал" буюу хөлөг онгоцны багийн гишүүд, зорчигчид болон бусад хүмүүсийн гэмтэл, түүнчлэн хөлөг онгоцны улмаас бусдад учирсан эд хөрөнгийн хохирёлын даатгалын бүтээгдэхүүнийг манай зүгээс санал болгосон юм. Монголын даатгалын компаниудад хөлөг онгоцны даатгалын дээр дурьдсан тодорхой бүтээгдэхүүний хувилбарт боломжийг санал болгосон ч монголын даатгалын компаниуд энэ талын даатгалын бүтээгдэхүүн гаргах боломж одоогоор байхгүй мөн судалж байж цаашид хариу өгөхөөр болсон бөгөөд энэ талаар цаашид даатгалын компаниудын чадамжийн хүрээнд бололцоо хомс гэдгээ илэрхийлсэн.	
ЗОРИЛТ 5. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, СТАТИСТИК МЭДЭЭ ГАРГАН, ХЭРЭГЛЭГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАНА.		АЖЛЫН ЯВЦ	ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН 2017 ОНЫ 158 ДУГААР ТУШААЛ, 2023 ОНЫ А/60 БОЛОН А/88 ДУГААР ТУШААЛ	ХӨЛӨГ ОНГОЦНЫ БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ ЦАХИМААР ОЛГОЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК МЭДЭЭГ ХАГАС, БҮТЭН ЖИЛЭЭР ГАРГАЖ ТАЙЛАГНАНА.	I-IV УЛИРАЛ	
5.1.	Усан замын тээврийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлэх	Гүйцэтгэлийн хувь	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 158 дугаар тушаалаар баталсан "Усан замын тээврийн тээвэрлэлтийн жилийн статистикийн тайлан мэдээний маягтаар аж ахуйн нэгж, иргэдээс тээвэрлэлтийн	3-р улиралд: Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдээс тайлан, мэдээ авах ажлыг зохион байгуулсан байна. 4-р улиралд: Статистик мэдээг нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тээвэрлэлтийн мэдээг авах ажлыг зохион байгуулж, нэгтгэн Үндэсний статистикийн хорооны даргын баталсан хавсралтын дагуу Усан замын тээврийн 2024 оны тээвэрлэлтийн тоон мэдээг нэгтгэн 2024 оны 10 дугаар сарын 25-ны 01/436 тоот албан бичгээр ЗТХЯ-ны БТГ-т хүргүүлсэн.	100

			мэдээг жил бүр нэгтгэн ЗТХЯ-нд хүргүүлдэг.			
5.2.	Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны ачаа тээврийн мэдээг нэгтгэн боловсруулах	Ажлын явц	Хөлөг онгоцны ачаа тээвэрлэлтийн мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажилладаг.	2-р улиралд: Мэдээг эхний хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна. 4-р улиралд: Мэдээг жилийн эцсийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Хөлөг онгоцны ачаа тээврийн мэдээг 2024 оны 06 дугаар сарын 19-ний 01/237, 2024 оны 12 дугаар сарын 15-ны 01/510 тоот албан бичгээр тус тус ЗТЯ-нд хүргүүлсэн.	100
5.3.	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг нэгтгэн боловсруулах	Ажлын явц	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны мэдээг улирал, хагас, бүтэн жилээр гаргаж холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажилладаг.	1-4-р улиралд: Мэдээг гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааны тайлан мэдээг жилийн эцсийн байдлаар гарган Далайн захиргааны даргын 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 01/540 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	100
5.4.	Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах зорилгоор Хөвсгөл аймгийн Хатгал тосгон дахь усан замын зогсоолын орчмын хог хаягдлыг бууруулах чиглэлээр олон нийтэд сурталчилгаа хийх, эрэг дагуух хогийг цэвэрлэх нэгдсэн арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	Далайн захиргааны хэлтэс, албадын мэргэжилтнүүд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд нуурын эргийн дагуух хог, хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2022 онд зохион байгуулсан.	3-р улиралд: Нэгдсэн арга хэмжээг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулж, тайланг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	Хөвсгөл нуурын эрэг дагуух хог хаягдлыг цэвэрлэх арга хэмжээг 2024 оны 09 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд орон нутгийн иргэд, завьчидтай хамтран 6 дахь жилдээ Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгууллаа. Энэ жил хог цэвэрлэх арга хэмжээг “Хүзүүвчийн шил”-ийн усан замын зогсоолоос Сүхбаатар усан онгоцны зогсоол хүртэлх нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэсэн. Энэ талаарх мэдээг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд байршуулсан. Мөн мэдээллийг усан замын тээврийн 2024 оны хөвөлтийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын нэгдсэн тайланд тусгагдсан. (Далайн захиргааны 2024 оны 01/489 тоот)	100
5.5.	Цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлж ажиллах		Далайн захиргааны 2023 оны цахимжуулах үйл ажиллагааны	1-р улиралд:	Зам, тээврийн яамны холбогдох газраас 2024 онд Зам, тээврийн салбарын цахимжуулах үйл ажиллагааны	

		Гүйцэтгэлийн хувь	төлөвлөгөө хэрэгжилтийг баталж, хангаж ажилласан.	Цахимжуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. 2-4-р улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, ЗТЯ-нд тайлагнаж ажилласан байна.	төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд, Бодлого төлөвлөлтийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана, Далай, усан замын чиглэлээр тусгагдсан ажил үйлчилгээ байхгүй гэж мэдэгдсэн. Тухай бүрт нь ЗТЯ-аас чиглэл ирсэний дагуу зохион байгуулж буй арга хэмжээнд оролцож салбарын цахимжуулахтай холбоотой хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг танилцуулж ажилласан.	0
5.6.	Хөлөг онгоцны бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгох	Ажлын явц	Хөлөг онгоц бүртгэлийн гэрчилгээг цахимаар олгох, цахимаар бүртгэл баталгаажуулах хөгжүүлэлт программ хангамжид хийгдэж дууссан	1-р улиралд: Олон улсын далайн байгууллага болон бусад холбогдох байгууллагад цахим гэрчилгээ олгож эхэлсэн талаар мэдэгдэх 2-3-р улиралд: Хөлөг онгоцны гэрчилгээг цахимаар олгож эхэлсэн байна.	Олон Улсын Далайн байгууллага болон холбогдох байгууллагуудад Монгол Улсын Далайн захиргаанаас цахим гэрчилгээ олгож эхэлсэн талаар мэдэгдэл хүргүүлж, 2024 оны 07 дугаар сараас эхлэн хөлөг онгоцны бүх төрлийн гэрчилгээг цахимаар олгож байна.	100
ЗОРИЛТ 6. ХОЁР БОЛОН ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЖ, ОЛОН УЛСЫН ХУРАЛ САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛНА.		АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	МОНГОЛ УЛС “ХУУРАЙ БООМТЫН ТУХАЙ” ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭРТ 2016 ОНД НЭГДЭЖ ОРСОН.	“ХУУРАЙ БООМТЫН ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭЛЭЛЦЭЭР”-Т НЭГДСЭН АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ОРНУУДЫН ДАЛАЙН БООМТУУД БОЛОН ХУУРАЙ БООМТУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХУУРАЙ БООМТЫН ЭХЛЭЛ ЦЭГ БОЛОХ ДАЛАЙН БООМТЫГ СОНГОН, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛНЭ.	I-IV УЛИРАЛ	

6.1.	<p>“Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд Замын-Үүд, Улаанбаатар байршлуудад эхлэл цэг болох далайн боомтыг сонгох, хамтын ажиллагааг эхлүүлэх</p>	Ажлын явц	<p>Монгол Улс “Хуурай боомтын тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2016 онд нэгдэж орсон.</p>	<p>2-р улиралд: Далайн боомтуудтай холбоо тогтоож, харилцаа хамтын ажиллагааг эхлүүлсэн байна.</p>	<p>Далянь боомттой хамтран ажиллах талаар Далайн захиргааны төлөөлөл 2024 оны 1 дүгээр сард Далянь боомтод ажилласан бөгөөд тус боомтоор дамжуулан Монгол Улсын импортын автомашиныг задгайгаар тээвэрлэх туршилтын тээвэр зохион байгуулахаар мэдээлэл солилцсон.</p> <p>БНХАУ-тай 2014 онд байгуулсан ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд Ляонин мужийн далайн боомтуудыг МУ-ын хуурай боомтын эхлэл цэг болгох ажлыг эхлүүлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор тус мужийн Шэньян хотод төлөөлөгч томилох асуудлаар яриа хэлэлцээр хийсэн. Уг ажлын хүрээнд Далайн захиргааны төлөөлөгч ажиллуулах хүсэлтэй байгаа талаар ЗТХ-ийн сайдаас Ляонин мужийн даргад холбогдох хүсэлтийг уламжилж, шийдвэр гаргуулахад дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийн төслийг боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 01/178 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Ляонин мужийн далайн боомтуудтай харилцаа хамтын ажиллагааг эхлүүлэх талаар 2024 оны 09 дүгээр сарын 23-нд Далянь боомттой МУ-ын импортын ачаа барааг дамжуулан тээвэрлэхэд хамтарч ажиллах уулзалтуудыг хийсэн ба холбогдох ажлын хэсэг тээвэрлэлт эхлүүлэх талаар мэдээлэл солилцож хамтарч ажиллаж байна. Мөн Жинжоу боомттой 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр ЗТЯ-ны холбогдох ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамтаар Монгол Улсын экспортын уул уурхайн бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх талаар санал солилцох уулзалтуудыг</p>	100
------	--	-----------	--	--	--	-----

					хийсэн ба уг уулзалтын үр дүнд хоёр талын ажлын хэсгийг томилон мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, холбогдох ажлуудыг авч хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тушаалын төслийг бэлтгэн ЗТ-ийн сайдын зөвлөхөд 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр цахимаар хүргүүлсэн. Мөн Хятадын хуурай боомт хөгжүүлж буй сайн туршлагаас суралцах, далайн боомт болон хуурай боомтуудтай хамтын ажиллагаа тогтоох зорилгоор БНХАУ-ын “Хуурай боомтын холбоо”-той 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Бээжин хотод уулзалт хийж цаашид Санамж бичиг байгуулан хамтарч ажиллах боломжтой талаар тохиролцсон.	
6.2.	Далайн салбарын байгууллагуудтай байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгүүдийн дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх	Ажлын явц	Монгол Улсын Далайн захиргаа нь АНУ, БНСУ, БНХАУ, Вьетнам Улс, Австралийн Холбооны Улс зэрэг улсуудтай далайн салбарын чиглэлээр хамтран ажиллаж байна.	1-4-р улиралд: Санамж бичгийн хүрээнд 2024 онд хамтран хэрэгжүүлэх боломжит арга хэмжээний саналыг боловсруулан хамтран ажиллагч байгууллагуудад хүргүүлж, хамтран ажилласан байна.	Монгол Улсын Далайн захиргаа хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд Монгол Улсад суугаа Америкийн нэгдсэн улсын далайн салбар хариуцсан албан хаагчтай цаг үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор 3 удаа уулзалт зохион байгуулсан, БНСУ-ын Далайн институттэй харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулсан, Вьетнам улстай санамж бичгийн хүрээнд ажил эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 1 дүгээр сард төлөвлөгөөг батлахаар тохиролцсон, БНХАУ-ын Ляонин мужийн Далянь далайн хэргийн их сургууль, Тэнгисийн их сургуультай санамж бичиг тус тус байгуулсан, Австралийн Холбооны улстай хамтран ажиллах хүсэлтэй илэрхийлсэн боловч санамж бичиг зурах хугацааг 2025 онд байгуулах талаар эргэн хариу мэдэгдсэн.	30
				1-2-р улиралд:	БНСУ-ын Далайн институттэй харилцан ойлголцлын Санамж бичиг 2024 оны 09	

6.3.	Бусад улсын далайн салбарын эрх бүхий байгууллагуудтай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэх	Ажлын явц	Тайландын Хаант Улсын Далайн захиргаатай хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичгийн бичиг байгуулахаар ажиллаж байна. БНСУ-ын Далайн институттэй хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын Санамж бичиг байгуулахаар харилцан тохиролцсон.	Хамтран ажиллах боломжтой байгууллагуудын судалгааг хийсэн байна. 3-р улиралд: Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар мэдээлэл солилцож ажилласан байна. 4-р улиралд: Монгол Улсын Далайн захиргаатай ижил түвшний 1-2 байгууллагуудтай шинээр холбоо тогтоож, хамтран ажиллах саналыг хүргүүлж, бэлтгэл ажлуудыг хангасан байна.	дүгээр сарын 10-ны өдөр Бусан хотноо байгуулсан. Тайландын Хаант Улсын Далайн захиргаатай Санамж бичгийг 11 дүгээр сарын 01-ний өдөр Бангкок хотод байгуулсан.	100
6.4.	Ажилтнуудыг салбарын олон улсын хурал, зөвлөгөөнд хамруулах	Ажлын явц	2023 онд далайн тээврийн салбарын нийт 7 сургалт, семинарт 30 ажилтныг хамруулсан.	1-4-р улиралд: Хурал, зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг хамруулахад дэмжлэг үзүүлж ажилласан байна.	Олон Улсын Далайн байгууллагаас Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад 2024 оны 03 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд зохион байгуулсан Далайн орчныг хамгаалах хорооны (MEPC) 81 дүгээр хуралдаанд Монгол Улсын Далайн захиргааны төлөөллийг оролцуулсан. АНУ-ын Төрийн департаментаас санаачилан Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газартай хамтран зохион байгуулсан “Олон улсын далайн хориг арга хэмжээнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа” (“2024 RISC”) сэдэвт 2 дахь удаагийн зөвлөгөөнд Монгол Улсын Далайн захиргаа болон Зам, тээврийн хөгжлийн яамны төлөөлөл илтгэл тавьж оролцсон. Олон Улсын Далайн байгууллагын Далайн орчныг хамгаалах хорооны (MEPC) 82 дугаар хуралдаанд Монгол Улсын Далайн захиргааны төлөөллийг 09 дүгээр сарын 23-аас 10 дугаар сарын 04-ний өдрүүдэд оролцуулсан.	100

					Олон Улсын Далайн байгууллагаас зохион байгуулсан Тэнцвэржүүлэгч усны конвенцын сургалтад Сингапур улсад 11 дүгээр сарын 12-оос 11 дүгээр сарын 14-ний хооронд 2 төлөөлөгч хамруулсан.	
6.5.	“Хуурай боомтын тухай Засгийн газрын хэлэлцээр”-т нэгдсэн Ази, Номхон далайн бүсийн орнуудын далайн боомтууд болон хуурай боомтуудын хамтын ажиллагааны олон улсын чуулга уулзалтыг санаачилан зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	-	2-3-р улиралд: Бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна. 4-р улиралд: Арга хэмжээг зохион байгуулсан байна.	НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын Зүүн болон зүүн хойд Азийн салбартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр ГХЯ-ны Зөвшилцөл танхимд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.	100
6.6.	Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагын зөвлөлийн 24 дүгээр зөвлөгөөнд оролцох	Гүйцэтгэлийн хувь	Монгол Улсын Далайн захиргаа 2018 онд АФОМСА-д гишүүнээр элссэн 23 дугаар зөвлөгөөнийг АХУ-ын Далайн аюулгүйн байдлын газартай хамтран зохион байгуулсан.	2-р улиралд: Ази, Номхон далайн бүс нутгийн Далайн тээврийн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагуудын 24 дүгээр зөвлөгөөнд холбогдох албан тушаалтнуудыг оролцуулах арга хэмжээг авсан байна.	Зохион байгуулах орон болох БНХАУ-ын зүгээс Ази, Номхон далайн бүс нутгийн далайн аюулгүй байдлын агентлагуудын удирдлагын зөвлөлийн зөвлөгөөнийг 2025 оны 03 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулахыг албан ёсоор мэдэгдсэн.	0
6.7.	Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг мэдээллийн олон сувгийг ашиглан олон нийтэд сурталчилан таниулах	Олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо, давтамж	Үйл ажиллагааны томоохон өөрчлөлт, дэвшлийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан	1-4-р улиралд: Олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо, давтамжийг 30-аас доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	Салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд сурталчилан, таниулах зорилгоор 2023 онд Фейсбүүк пейж хуудсанд нийт 219 2024 онд 291, байгууллагын веб сайтад 2023 онд нийт 73, 2024 онд 145 мэдээ, мэдээлэл бэлтгэн байршуулсан.	100
ЗОРИЛТ 7. ДАЛАЙН ЗАХИРГААНЫ 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАНА.		АЖЛЫН ЯВЦ	МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ДАЛАЙН БАЙГУУЛЛАГА, ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНТ ХИЙМЭЛ ДАГУУЛЫН БАЙГУУЛЛАГА, ОЛОН УЛСЫН ДАЛАЙН ЁРООЛЫН БАЙГУУЛЛАГАД	МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨЛБӨРИЙГ НЭХЭМЖЛЭЛИЙН ДАГУУ БАРАГДУУЛЖ, УЛСЫН ТӨСӨВТ 300 САЯ	I-IV УЛИРАЛ	

			ГИШҮҮНЭЭР ЭЛСЭН ОРЖ, ОЛОН УЛСЫН ӨМНӨ ҮҮРЭГ ХҮЛЭЭЖ БАЙНА.	ТӨГРӨГИЙГ ТӨВЛӨРҮҮЛНЭ.		
7.1.	Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын олон улсын байгууллагын төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулах	Гүйцэтгэлийн хувь	Монгол Улс Олон улсын далайн байгууллага, Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллага, Олон улсын далайн ёроолын байгууллагад гишүүнээр элсэн орж, олон улсын өмнө үүрэг хүлээж байна.	3-р улиралд: Нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлж барагдуулсан байна.	2024 оны 4 дүгээр улирлын байдлаар далайн салбарын олон улсын байгууллагын төлбөр 164,867,927.24 төгрөгийн гадаад шилжүүлэг, улсын төсөвт төвлөрүүлэх 300,000,000.00 төгрөгөөс нийт 300,000,000.00 төгрөгийг төвлөрүүлж 100% гүйцэтгэлтэй байна.	100
7.2.	Үндэсний аудитын газар болон бусад хяналт шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах	Гүйцэтгэлийн хувь	2023 онд Үндэсний аудитын газраас ирүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг хуулийн хугацаанд хэрэгжүүлж тайлагнав.	4-р улиралд: Зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн тухай албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн байна.	2023 оны санхүүгийн үйл ажиллагааны аудит зөрчилгүй дүгнэлтийг Үндэсний аудитын газрын 2024 оны 07/713 тоотойр “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй гарсан. Мөн аудитын зөвлөмжийн хүрээнд хэрэгжилтийг 2024 оны 01/309, 01/310 тоот албан бичгүүдээр биелэлтийг “Гэрэлтэх бүртгэл аудит ХХК”-д, ЗТЯ-ны ХШҮДАГ-т тус тус хүргүүлсэн. Мөн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар болон “Гэрэлтэх бүртгэл аудит” ХХК-иас ирүүлсэн 2024 оны 02/241, 02/238 тоот албан бичгүүдээр “Завсарын аудит” орсон бөгөөд санхүүгийн болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг хүлээлгэн өгсөн.	100
7.3.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, худалдан авах ажиллагааг ЗТХЯ-нд тайлагнаж ажиллах	Гүйцэтгэлийн хувь	Худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр ЗТХЯ-нд хүргүүлж хэвшсэн.	1-4-р улирал: Тухайн онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааг улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар ЗТХЯ-нд тайлагнасан байна.	Далайн захиргааны 2024 оны Худалдан авах ажиллагааны тайланг 4 дүгээр улирлын байдлаар 2024 оны 12 дугаар сарын 27-ны 01/568 тоот албан бичгээр ЗТЯ-нд хүргүүлсэн.	100

<p>ЗОРИЛТ 8. САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БЭЛТГЭЖ, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛААР ХАНГАХ</p>	<p>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙ ЯВЦ, ХУВЬ</p>	<p>ШУТИС-ИЙН МЕХАНИК, ТЭЭВРИЙН СУРГУУЛЬТАЙ ТЭЭВРИЙН САЛБАРТ БОЛОВСОН ХҮЧИН БЭЛТГЭХЭД ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР 2018 ОНД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН.</p>	<p>“ДАЛАЙН ТЭЭВЭР, БООМТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА” СЭДЭВТ ХИЧЭЭЛИЙГ ХУВААРИЙН ДАГУУ ЗААЖ САНАМЖ БИЧГИЙН ХҮРЭЭНД ХАМТАРЧ АЖИЛЛАНА.</p>	<p>I-IV УЛИРАЛ</p>		
<p>8.1.</p>	<p>Гадаадын их, дээд сургууль, сургалтын төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчнийг сургаж бэлтгэх, мэргэшүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллах</p>	<p>Үйл ажиллагааны явц, хувь</p>	<p>Далайн салбарын мэргэшүүлэх сургалтад 2023 онд 10 албан хаагчийг хамруулсан.</p>	<p>1-р улиралд: Салбарын боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх талаар судалгаа хийж, сургалтын төлөвлөгөөг баталсан байна.</p> <p>2-4-р улиралд: Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.</p>	<p>Далайн захиргааны ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх 2024 оны сургалтын хөтөлбөр”-ийг 2024 оны А/12 дугаар тушаалаар баталсан. Япон Улсын Засгийн газрын Олон улсын хамтын ажиллагааны агентлагаас “Мэдлэг хамтран бүтээлцэх” хөтөлбөрийн хүрээнд Япон Улсын Токио хотод 2024 оны 02 дугаар сарын 04-17-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Олон улсын нийтийн эрх зүй: Далайн эрх зүйн тухай конвенц ба олон улсын маргааныг энхийн журмаар шийдвэрлэх” нь сэдэвт сургалтад ЗТХЯ болон Далайн захиргаанаас холбогдох албан тушаалтнууд оролцсон. Байгууллагын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн сургалтыг цахимаар 2024 оны 02 дугаар сарын 05, 15-нд нийт 13 албан хаагчийг хамруулсан. -Сургалтын хөтөлбөрийн хүрээнд байгууллагын нийтлэг соёл болон хувь хүний хөгжилд чиглэгдсэн сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 29-нд “Жей Си Ай Цэнтрал Сан академ”-аас зохион</p>	<p>100</p>

					байгуулж нийт албан хаагчид хамрагдсан. -Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, тохирлын гэрчилгээ авах ажлын бэлтгэлийг хангаж ISO9001:2015 стандарт хэрэгжүүлэх сургалтыг 03 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж удирдлагууд болон нийт 20 ажилтан, албан хаагч хамрагдсан.	
8.2.	ШУТИС-ийн Механик, тээврийн сургуульд мэргэжлийн туслалцаа дэмжлэг үзүүлэх, салбарын боловсон хүчин бэлтгэх зорилгоор “Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа” сэдэвт сонгон суралцах хичээлийг хөтөлбөрийн дагуу оюутнуудад зааж хамтран ажиллах	Үйл ажиллагааны явц, хувь	ШУТИС-ийн Механик, тээврийн сургуультай тээврийн салбарт боловсон хүчин бэлтгэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор 2018 онд Хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулсан. 2019 оны хичээлийн жилээс эхлэн “Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа” сонгон суралцах хичээлийг оюутнуудад зааж мэргэжлийн туслалцаа үзүүлсэн.	2-р улиралд: “Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа” сэдэвт хичээлийг хуваарийн дагуу зааж санамж бичгийн хүрээнд хамтарч ажилласан байна.	ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуультай 2023-2024 оны хичээлийн жилийн II улиралд нийт 9 оюутанд “Далайн тээвэр, боомтын үйл ажиллагаа” ETR449 код бүхий 3 кредитийн хичээлийг батлагдсан хөтөлбөрийн дагуу зааж эзэмшүүлсэн.	100
8.3.	Хүний нөөцийн удирдлагатай холбоотой нийтлэг үйлчилгээ, өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Далайн захиргааны ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөр 2022-2024 он хүртэл батлагдсан.	1-4-р улиралд: Хүний нөөцтэй холбоотой бүхий л асуудлыг цаг тухайд нь шийдвэрлүүлж, хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Далайн захиргааны даргын 2024 оны “Ээлжийн амралт батлах тухай” Б/01 дугаар тушаал батлагдсан бөгөөд шинээр ажилд орж буй албан хаагчдад ажлын үнэмлэх олгох, дотоод системд бүртгэх зэрэг хүний нөөцтэй холбоотой асуудлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. Байгууллагын ажлын байрны сул орон тоо үүссэн тохиолдолд байгууллагын дотоод журамд заасны дагуу тус сул орон тоо үүссэн албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтод заасан тавигдах шаардлагын дагуу байгууллагын цахим хаягт холбогдох ажлын байрнуудын	30

					сонгон шалгаруулалтыг зарлан ил тод байдлыг ханган ажилласан. Далайн захиргааны даргын 2022 оны “Ажилтнуудын нийгмийн баталгааг 2022-2024 онд хангах хөтөлбөр” 43 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хөтөлбөрт заагдсан арга хэмжээний дагуу Далайн захиргааны даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар цалин, хөлсийг 10%-иар нэмэгдүүлсэн. Мөн даргын 2024 оны А/05 дугаар тушаалаар хоол унааны мөнгийг нэмэгдүүлсэн бөгөөд суутгал шимтгэл зэрэг мэдээг сар бүр албан хаагч тус бүрийн цахим хаяг руу илгээж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	
8.4.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Далайн захиргааны ХАБЭА-н үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батлуулсан байна.	1-р улиралд: ХАБЭА-н үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө батална. 2-р улиралд: Хуулийн хэрэгжилтийн тайланг хагас жилийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлнэ. 4-р улиралд: Хуулийн хэрэгжилтийн тайланг жилийн эцсийн байдлаар гаргаж, ЗТХЯ-нд хүргүүлнэ.	ХАБЭА-н үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр баталж, ЗТЯ-ны ХАБЭА хариуцсан мэргэжилтэнд цахимаар болон Далайн захиргааны даргын 2024 оны 01/554 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100
ЗОРИЛТ 9. ДАЛАЙН БОЛОН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨГӨӨР ХАНГАН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ АЖИЛЛАНА.		АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО	2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР УЛСЫН БҮРТГЭЛД НИЙТ 206 ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ БҮРТГЭЖ, ГЭРЧИЛГЭЭ, УЛСЫН ДУГААР ОЛГОСОН.	АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭДИЙГ ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАЖ АЖИЛЛАНА.	I-IV УЛИРАЛ	

9.1.	Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээ, улсын дугаар олгох, шилжилт, хөдөлгөөн хийх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэх	Үйл ажиллагааны явц, хувь	Усан замын тээврийн хэрэгслийг шинээр бүртгүүлэх, бүртгэлд шилжилт хөдөлгөөн хийх, хасалт хийлгэх хүсэлтийг 2022 оноос эхлэн Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia-аар дамжуулан хүлээн аван шийдвэрлэх боломжтой болсон. 2023 оны жилийн эцсийн байдлаар улсын бүртгэлд нийт 206 тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээ, улсын дугаар олгосон.	1-4-р улиралд: Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангаж, ирүүлсэн хүсэлт, өргөдлийг шийдвэрлэсэн байна.	2024 оны байдлаар улсын бүртгэлд 233 усан замын тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна. E-Mongolia-аар дамжуулан шинээр бүртгүүлэх-27, шилжилт хөдөлгөөн хийлгэх-19, хөдөлгүүрийн өөрчлөлтийг бүртгүүлэх 4 хүсэлт, өргөдлийг тус тус хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлээд байна. Усан замын тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх, шилжилт хөдөлгөөн хийлгэх талаар мэдээлэл, зөвлөгөө авахаар хандсан 60 орчим иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг Зам, тээврийн сайдын шуурхай хуралдаанд тухай бүр танилцуулж, Зам, тээврийн салбарын нэгдсэн платформд оруулаад байна.	100
9.2.	“Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	Усан замын тээврийн хөвөлтийн улирал эхлэх үед хамтарсан семинарыг жил бүр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулдаг.	3-р улиралд: Сургалт, семинарыг зохион байгуулж, холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулсан байна.	“Усан замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах нь” сэдэвт семинарыг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд зохион байгуулсан. Семинарт Зам, тээврийн яам, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ, Монгол даатгал ХК болон усан замын тээврийн ажил, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий нийт 80 гаруй хүн оролцсон. Түүнчлэн Архангай аймгийн Өгийнуур суманд усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулсан сургалтыг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.	100
					Монголын тээвэр, зуучлагчдын нэгдсэн холбоотой Монгол Улсын тээвэр,	

9.3.	Монгол Улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг хөрш орнуудын боомтоор дамжуулан тээвэрлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхэд оролцогч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын хооронд зөвлөлдөх уулзалт, ярилцлагыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь	“Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай 2018 онд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд жил бүр зохион байгуулахаар тусгагдсан.	2-р улиралд: Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж мэдээлэл солилцож ажилласан байна. 4-р улиралд: Зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.	логистикийн салбарт тулгарч буй цаг үеийн асуудлаар мэдээлэл солилцож, хамтран ажиллаж байна. Үүнд: -Боомтын сэргэлт үндэсний форум арга хэмжээний хүрээнд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр уулзалт хийж мэдээлэл, солилцож ажиллав. -Хуурай боомтын чиглэлээр цаг үеийн мэдээлэл солилцох уулзалт 2024.04.29 -Тяньжин боомтын нөхцөл байдлын талаарх санал солилцох уулзалт 2024.05.10 -МТЗНХ-ны удирдах зөвлөлийн гишүүдтэй хуурай боомт болон импортын ачаа тээвэрлэлтийн талаар цаг үеийн мэдээлэл солилцох, цаашид хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцох уулзалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Далайн захиргааны байранд зохион байгуулав. МТЗНХ-той санал солилцох уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны 14:00 цагт Далайн захиргааны байранд зохион байгуулж, цаг үеийн болоод цаашид хамтран ажиллах боломжуудын талаар санал солилцсон ба Монгол Улсын Замын-Үүд байршилд байгуулах хуурай боомтод хамтран ажиллахаар болов.	100
------	--	-------------------	--	--	---	-----

Төлөвлөгөөг үнэлсэн:

Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан
(албан тушаал)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Төсвийн шууд захирагч

.....
(гарын үсэг)

Нэгжийн дарга

/...../
(огноо)

ХШҮДАГ-ын дарга А.Мөнхбат
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/...../
(огноо)

Тайлагнасан:
Далайн захиргааны даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч Б.Сайнбаяр
(албан тушаал)

Нэгжийн дарга

.....
(гарын үсэг)

/2024.12.18/
(огноо)